

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Үндэсний Аудитын газар УАГ-20/007 дугаартай **“Авто зам, гүүрний барилга, байгууламжийн зураг, төсөл, гүйцэтгэлд дүгнэлт гаргах”** зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. Дараах зөвлөх үйлчилгээг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл, хатуу хучилттай авто зам /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/;
- Автомашинны нийтийн эзэмшлийн зогсоолын барилга 6 дугаар хороо /Улаанбаатар, Баянгол дүүрэг/;
- Аймгийн төвийн гудамж, талбайн гэрэлтүүлэг /Баян-Өлгий аймаг, Өлгий сум/;
- Гэр хорооллын дахин төлөвлөлт: багц 1. Цас тогтох дэлгүүрээс заяшк хүртэлх 0.8 км замын ажил /7 дугаар баг/ /Увс аймаг, Улаангом хот/;
- Гэр хорооллын дахин төлөвлөлт: багц 2. Гэр хороололд тавигдах 2.1 км замын ажил /7 дугаар баг/ /Увс аймаг, Улаангом хот/;
- Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2,8 км хүртэл /1 дүгээр баг/, /Увс аймаг, Улаангом/;
- Хороодын доторх авто замын засвар, тохижилт /6,15,18,25 дугаар хороо/, /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг/;
- Намирын голын төмөр бетон гүүр, авто зам /Увс аймаг, Өмнөговь сум/;
- Согоогийн голын төмөр бетон гүүр /Баян-Өлгий аймаг, Улаанхус сум/;
- Ширээгийн голын төмөр бетон гүүр, 90.9 у/м, /Завхан аймаг, Цагаан хайрхан сум/;
- Хараа голын төмөр бетон гүүрний засвар, 135 у/м, /Дархан -Уул аймаг, Дархан/;
- Шавартайн голын төмөр бетон гүүрний их засвар, шинэчлэлт, 39.8 у/м, /Төв аймаг, Борнуур сум/

1. Энэ зөвлөх үйлчилгээ нь **авто зам, гүүрний барилга, байгууламжийн зураг, төсөл, гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилгын норм, дүрэм, стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргах** болно.
2. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн **2** жилийн (**2018, 2019 он**) **дундаж** борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн **50** хувиас багагүй байна.

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Сүүлийн **2** жил буюу **2018, 2019** оны аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн **30** хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх. /Магадлан экспорт хийсэн төслийн гэрээ, хүлээлгэж өгсөн батлагдсан нүүр хуудас буюу акт, тухайн ажлыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн захиалагчийн тодорхойлолт тус бүрийг хуулбарлан ирүүлнэ/.

Инженер, техникийн дараах ажилтнуудын мэдээлэл ирүүлнэ.

- Авто замын зураг төсөл боловсруулах чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай, мэргэшсэн инженер,
- Авто замын барилга угсралтын чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан ажлын дадлага туршлагатай мэргэшсэн инженер,

- Авто замын болон гүүрэн байгууламжийн төсөв боловсруулах, хянах, магадлал хийх эрхтэй, тэргүүлэх зэрэгтэй төсөвчин,
- Гүүр, ус зайлуулах байгууламжийн барилга угсралтын чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан, туршлагатай, мэргэшсэн инженер зэрэгтэй,
- Гүүрийн зураг төсөл боловсруулах чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан ажлын дадлага туршлагатай, мэргэшсэн инженер

Магадлал буюу эксперт хийх эрхтэй боловсон хүчин байна:

- Гүүрийн барилга байгууламжийн 40-өөс доошгүй зураг төсөл боловсруулсан байх, жагсаалтыг хэрэгжүүлсэн он, тухайн төсөл арга хэмжээний нэр, өртөг, захиалагчийн хаяг, холбогдох утас зэрэг мэдээллийг багтаан хүснэгтэд хийн ирүүлэх;
- Мэргэжлийн чиглэлийн 3-аас доошгүй барилгын норм нормативын баримт бичиг, стандарт /гарын авлага, зөвлөмж/ боловсруулсан, боловсруулахад хамтран оролцсон байх;
- Өөрийн мэргэжлийн чиглэлийн норм, нормативын баримт бичгийн сантай байх.
- Зөвлөх нь гүйцэтгэх хүсэлтэй тухайн зөвлөх үйлчилгээний зураг төсөв, барилгын ажилд оролцоогүй байх, тэр тухайгаа албан бичгээр батлан ирүүлнэ.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:үгүй

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

3. Мэдүүлгийг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 10 цаг 00 минутаас эхлэн 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 10 цаг 30 минут хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 10 цаг 50 минутын дотор ирүүлнэ үү.

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр, 04 дүгээр давхар,
Үндэсний Аудитын газар,
Утас: 32 98 70

www.tender.gov.mn, www.audit.mn www.rtdc.dov.mn